

## ТӨВИЙН ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ, ЭРХЛЭХ АСУУДАЛ

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв нь Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн Газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн Газар хоорондын хэлэлцээр, хоёр улсын холбогдох яамдын хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгал, нийгмийн халамж, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн төрийн үйлчилгээг үзүүлэх, мэдээллээр хангах чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага юм<sup>1</sup>.

Тус төв нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон салбарын бодлого, үндэсний болон дэд хөтөлбөр, салбарын сайдын тушаал, шийдвэрүүдийг хэрэгжүүлж, ажлын явц, үр дүнг яам, харьяа агентлагуудад тайлагнаж ажилладаг.

Төвийн гүйцэтгэдэг зарим чиг үүргээс дурьдвал:

- БНСУ-д оршин сууж буй Монгол Улсын иргэдэд хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, гэр бүл, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тухайлбал:
  - БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдэд хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны талаар эрх зүйн зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн гэрээний биелэлтийг хангуулахад дэмжлэг туслалцаа үзүүлэх;
  - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас илгээсэн БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирж буй иргэдийг Хөдөлмөр, хөгжлийн сангийн харьяа Ёжү хот дахь Олон улсын сургалтын төвд ирсний дараах сургалтад хамруулах;
  - Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны талаар Монгол Улсын иргэдэд хууль тогтоомж, бодлого зохицуулалтын талаар мэдээлэл өгөх өдөрлөг, сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулах;
  - Иргэнээ үйлчилгээний танхимаар хүлээн авч, мэдээлэл зөвлөгөө өгөх, гаргасан санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд хариу өгөх, шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авах;
  - Байгууллагын web болон page хуудсаар цахим орчинд иргэддээ зориулсан мэдээ, мэдээлэл түгээх, өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч, шуурхай хариу өгөх онлайн үйлчилгээ үзүүлэх;
  - Байнгын ажиллагаатай лавлах утас ажиллуулж, санал хүсэлт, гомдол мэдээллийг шуурхай авч, шийдвэрлэх арга хэмжээ авах;
  - БНСУ-д оршин сууж буй хөдөлмөрийн гэрээт ажилчид, гэр бүл, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хууль эрх зүйн болон сэтгэл зүйн тулгамдсан асуудлаар зөвлөгөө өгөх;

---

<sup>1</sup> Монгол Улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн А/40 дугаар тушаалаар баталсан БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн дүрэм

- БНСУ-д оршин сууж байгаа Монгол хүүхэд, гэр бүлийн хамтын амьдрал, үнэт зүйлсийг дэмжин хөгжүүлэх, соён гэгээрүүлэх, холбогдох хууль тогтоомжийн талаарх мэдээллээр хангах, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;
- Хүүхэд, өсвөр үеийнхнийг хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь мэдээллийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд, өсвөр үеийнхэнтэй холбоотой ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах;
- БНСУ-д оршин сууж буй хүүхдүүдэд Монгол хэл, өв соёлд суралцах ажлыг зохион байгуулах;
- БНСУ-ын адил төстэй үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудтай хамтран ажиллах, хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Удаан хугацаанд тусдаа байсан гэр бүлийн гишүүдийн уулзалтыг зохион байгуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх;
- БНСУ-д оршин сууж байгаа Монгол иргэд хоорондын зөрчил, гэр бүлийн гишүүдийн хоорондын зөрчил, маргааныг зөв зохистой шийдвэрлэхэд хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, холбогдох байгууллагад холбон зуучлах;
- БНСУ-д оршин сууж байгаа Монгол иргэн өвдсөн, ар гэрт нь гачигдал гарсан, гэнэтийн осолд өртсөн, онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд зохих дэмжлэгийг үзүүлэх;
- БНСУ-ын адил төстэй үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудтай хамтран ажиллах, хамтын ажиллагааг өргөжүүлэх г.м.
- Төв нь БНСУ-д оршин сууж буй Монгол Улсын иргэдэд Монгол Улсын нийгмийн даатгалын асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлж ажилладаг. Тухайлбал:
  - БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулах, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд давхар хамрагдахгүй байх талаар мэдээллээр хангах;
  - БНСУ-д оршин сууж байгаа Монгол иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах, мэдээлэл, зөвлөгөө өгөх;
  - Нийгмийн даатгалын сангийн орлого, тэтгэврийн болон сайн дурын даатгалын шимтгэлийн орлого төвлөрүүлэх;
  - БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн иргэдийн шимтгэлийг буцаан олгуулах заавар, зөвлөгөө өгөх;
  - БНСУ-д оршин сууж байгаа Монгол иргэдийг Нийгмийн хамгааллын тухай хоёр улсын Засгийн Газар хоорондын хэлэлцээр болон Монгол Улсын Нийгмийн даатгалын ерөнхий хууль, тогтоомжуудын талаар мэдээллээр хангах, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;
  - БНСУ-ын адил төстэй үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудтай хамтран ажиллах, хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг болно.